

## ШИНЭ ИРГЭНШИЛ ДЭЭД СУРГУУЛИЙН 2017-2018 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ЭЛСЭЛТИЙН ЖУРАМ

### Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Боловсрол Шинжлэх Ухааны сайдын 2013 оны А/79 тоот тушаалаар батлагдсан “Оюутан элсүүлэх үлгэрчилсэн журам”-ыг үндэслэн боловсруулсан энэхүү журмыг баримтлан ШИДСургууль оюутан элсүүлэн суралцуулах болно.
- 1.2 Оюутан элсүүлэх ажлыг тус Сургуулийн захирлын тушаалаар баталсан элсэлтийн комисс зохион байгуулна.
- 1.3 ШИДС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт Улаанбаатар хот болон орон нутгаас элсүүлэх элсэгчийн хяналтын тоог Удирдах зөвлөл тогтооно.
- 1.4 Аж ахуйн нэгж, иргэдээс ирүүлсэн эрэлт хэрэгцээ, захиалга, сургуулийн материаллаг бааз, багшлах бүрэлдэхүүний хангамж зэргээс хамааран Боловсрол, Шинжлэх Ухааны Яамны тогтоосон элсэгчдийн хяналтын тоонд багтаан оюутан элсүүлнэ.
- 1.5 Элсэлтийн комисс нь элсэлтийн комиссын гишүүдийн ажил үүргийн хуваарилалт, оюутан элсүүлэх арга хэлбэр, элсэлтийн үед баримтлах хэм хэмжээ, дэг журам, элсэгчдийн материалыг шалгах болон ур чадварын шалгалтыг зохион байгуулан авах, өргөдөл гомдлыг барагдуулах, элсэлтийн явцад хяналт тавих зэрэг үйл ажиллагааг зохицуулах болно.
- 1.6 Хөдөө орон нутгаас элсэгчдийн бүртгэл болон хуваарь сонголтыг Монголын Их Дээд Сургуулиудын консорциумын /МИДСК/ 2017 онд аймаг орон нутгаас оюутан элсүүлэх журмыг баримтлан МИДСК-аас томилогдсон элсэлтийн комисс зохион байгуулна.

### Хоёр. Зохион байгуулалт

- 2.1 Тус сургуульд элсэх хүсэлтэй иргэн энэхүү журмын 3.4-т заасан ерөнхий шалгалт (ЕШ)өгнө.
- 2.2 Элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн мэргэжлээр суралцах хүсэлтэй иргэний өргөдлийг сургуулийн элсэлтийн комисс хүлээн авч, зохих хяналтын тоонд багтаан шалгаруулалт хийнэ.
- 2.3 ЕШ-ийг БСШУЯ-наас эрх олгосон хөндлөнгийн байгууллага эрхэлнэ.
- 2.4 Урьд нь дээд боловсрол эзэмшсэн иргэн хоёр дахь бакалаврын сургалтад хамрагдвал, мөн тус сургуулийн мэргэжлийн сургуульд суралцагчдаас шаталсан сургалтаар дэвшин суралцвал ЕШ авалгүйгээр элсүүлнэ.
- 2.5 Энэхүү журам болон элсэлтийн ажлын зохион байгуулалтын талаарх шаардлагатай мэдээлэл болон цахим бүртгэлийн талаарх мэдээллийг “Шинэ иргэншил” дээд сургуулийн вэб хуудас [www.nci.edu.mn](http://www.nci.edu.mn), БСШУЯ-ны

www.education.mn, боловсролын үнэлгээний төвийн www.eec.mn сайтаас танилцаж болно.

#### Гурав. Элсэгчдэд тавих шаардлага, авах шалгалт ба шалгаруулалт

- 3.1 ШИДС-д элсэгчид мэргэжлийн онцлогоос хамааран нийгмийн тухай мэдлэг, математик, монгол хэл, Монгол Улсын түүх, эсвэл гадаад хэлний хичээлээр шалгалт өгсөн байна.
- 3.2 Ерөнхий шалгалтын нийт онооны 50 ба түүнээс дээш хувийг авсан тохиолдолд элсэгч нь бүртгүүлэх эрхтэй.
- 3.3 Тус сургуульд элсэгч бүрэн дундаас доошгүй боловсролтой байна.
- 3.4 Доор дурдсан мэргэжлийн чиглэлүүдийг харгалзан ЕШ-ыг заавал өгсөн байна.  
Үүнд:

№	Мэргэжлийн чиглэл	ЕШ	Босго оноо
1	Менежмент ба удирдахуй <ul style="list-style-type: none"><li>• Аялал жуулчлалын менежмент</li><li>• Зочид буудал зоогийн газрын менежмент,</li><li>• Хүний нөөцийн менежмент,</li><li>• Маркетингийн менежмент,</li><li>• Хоол үйлдвэрлэл үйлчилгээний, менежмент</li></ul>	Математик, Гадаад хэл	400
2	Албан хэргийн менежмент	Монгол хэл, Математик	400
3	Иргэншил судлал	Түүх, Монгол хэл	400
4	Багш, нийгмийн ухаан Багш, сургуулийн өмнөх насны Багш, бага ангийн	Түүх, Монгол хэл	400
5	Нягтлан бодох бүртгэл Татварын нябо-хяналт Банкны менежмент	Математик, англи хэл /орос хэл/	400

#### Дөрөв. Өргөдөл хүлээн авах

- 4.1 “Шинэ иргэншил” дээд сургуульд элсэхийг хүсэгчийн өргөдөл, материалыг “Шинэ иргэншил” дээд сургуулийн элсэлтийн комисст өөрийн биеэр хүргэх бөгөөд хөдөө орон нутгаас элсэхийг хүсэгчид МИДСК-аас томилогдсон комиссоор дамжуулан ирүүлнэ.
- 4.2 Элсэхийг хүсэгч өөрийн гараар бичсэн өргөдөлдөө: товч намтар, ам бүлийн байдал, эцэг эх хаана ямар ажил, алба эрхэлдэг, ямар мэргэжлээр элсэх, уг мэргэжлийг сонгосон шалтгаан, мэргэжлийн чиглэлээр уралдаан тэмцээн, олимпиадад үзүүлсэн амжилт, ЕШ-ыг хэрхэн өгсөн, сургалтын төлбөрийг хэн хариуцах талаар бичиж, буцах хаяг, холбоо барих утас, e-mail хаягаа тодорхой

бичсэн байна. Элсэхийг хүсэгч нь өөрийн биеэр ирж бүртгүүлсэн тохиолдолд өргөдөл бичихгүй байж болно.

- 4.3 Боловсролын гэрчилгээ, иргэний үнэмлэхийн хуулбар, чээж зураг 2%, зэрэг материалыг бүрдүүлж өргөдөлд хавсаргасан байна. Бүртгэлийн хураамж 5000 төгрөгийг Голомт-1 банк дахь “Шинэ иргэншил” дээд сургуулийн 1102102604 тоот дансанд тушаасан орлогын мэдүүлгийн хамт ирүүлнэ.

#### Тав. Элсэхийг хүсэгчдийг шалгаруулах ба бүртгэх

- 5.1 Элсэгчдэд тавих шаардлагыг хангаж, шалгалт өгч тэнцсэн хүмүүсээс шалгаруулалт хийхдээ ЕШ-ын онооны нийлбэр дээр боловсролын гэрчилгээний дундаж оноог нэмсэн онооны нийлбэрээр жагсаалт хийж, удирдах зөвлөлийн тогтоосон хяналтын тоонд багтаан шалгаруулна.
- 5.2 Тэнцсэн хүмүүсийн нэрсийн жагсаалтыг сургуулийн веб-д 8-р сарын 25-ны дотор байрлуулан зарлана.
- 5.3 Тус сургуульд элсэх оюутны хяналтын тоонд багтаж шалгарсан хүмүүст суралцах эрхийн бичгийг 7-р сарын 5-аас 8-р сарын 30-ны дотор олгоно.
- 5.4 Шалгарагсад эрхийн бичиг авахдаа дараах материал бүрдүүлсэн байна.
- Бүрэн дунд боловсролын үнэмлэх буюу түүнтэй адилтгах бичиг баримт /эх хувь/
  - ЕШ-ын дүнгийн тодорхойлолт
  - Сурагчийн хувийн хэрэг /ажиллагсад нийгмийн даатгалын дэвтэр/
  - Иргэний үнэмлэх
  - Цээж зураг 2%
- 5.5 Холбоо барих хаяг:  
Шинэ иргэншил дээд сургууль  
Нэгдсэн үндэстний гудамж-б  
/Сангийн ямны хойд талд/  
Утас: 327198, 330195, 99922802, 99088697  
Имэйл: [ncinstitute@mongol.net](mailto:ncinstitute@mongol.net)  
Вэб: [www.nci.edu.mn](http://www.nci.edu.mn)

#### Зургаа. Сургалтын төлбөр

- 6.1 Монгол улсны боловсрол, шинжлэх ухааны сайдын А/92 тоот тушаалд үндэслэсэн ШИДС-ийн 2017-2018 оны хичээлийн жилийн сургалтын төлбөр:

№	Мэргэжлийн зэрэг, ангиуд	Анги тус бүрд ноогдох сургалтын төлбөрийн хэмжээ төгрөгөөр			
		I ангид элсэгчид	II ангид элсэгчид	III ангид элсэгчид	IV ангид элсэгчид
1	Бакалаврын өдрийн ангид	1400000	1400000	1400000	1400000
2	Бакалаврын эчнээ ангид	1400000	1400000	700000	-
3	Магистрын ангид	1500000		-	-

6.2 Тухайн жилийн сургалтын төлбөрийг 9 сарын 1-ний дотор төлж барагдуулах үүрэгтэй.

6.3 Сургалтын төлбөрийг хугацаанд нь төлсний хөнгөлөлт:

№	Төлбөр төлөх хугацаа	Хөнгөлөлтийн дүн
1	2017 оны 09 сарын 01-ны дотор /100% төлбөл/	280 000
2	2017 оны 09 сарын 01-ны дотор /50% төлбөл/	100 000
3	2018 оны 01 сарын 05-ны дотор /үлдэгдэл төлбөрөө төлбөл/	100 000

### Долоо. Оюутанд үзүүлэх тэтгэлэг тусламж

7.1 Шинэ Иргэншил Дээд сургууль дараах тэтгэлэг, тусламж болон хөнгөлөлтийг үзүүлнэ.

- Төрөөс оюутанд олгодог бүх төрлийн хөнгөлөлт
- БСШУСЯ-аас тогтоосон улс, аймаг, хотын хэмжээний уралдаан тэмцээнд оролцож шагналт байр эзэлсэн амжилт гаргасан оюутанд төлбөрийн хөнгөлөлт 20%
- “А” үнэлгээтэй суралцсан оюутан суралцагчдад дараахи төлбөрийн хөнгөлөлтийг үзүүлнэ.

1	Нэг улирал “А” үнэлгээтэй суралцвал дараагийн зөвхөн нэг улиралд нийт төлбөрөөс үзүүлэх хөнгөлөлтийн хувь	15%
2	Хоёр улирал дараалан “А” үнэлгээтэй суралцвал дараагийн зөвхөн нэг улиралд нийт төлбөрөөс үзүүлэх хөнгөлөлтийн хувь	25%
3	Гурван улирал дараалан “А” үнэлгээтэй суралцвал дараагийн зөвхөн нэг улиралд нийт төлбөрөөс үзүүлэх хөнгөлөлтийн хувь	35%
4	Дөрвөн улирал дараалан “А” үнэлгээтэй суралцвал дараагийн зөвхөн нэг улиралд нийт төлбөрөөс үзүүлэх хөнгөлөлтийн хувь	45%
5	Таван улирал дараалан “А” үнэлгээтэй суралцвал дараагийн зөвхөн нэг улиралд нийт төлбөрөөс үзүүлэх хөнгөлөлтийн хувь	55%
6	Зургаан улирал дараалан “А” үнэлгээтэй суралцвал дөрөвдүгээр курст нь нийт төлбөрөөс үзүүлэх хөнгөлөлтийн хувь	100%
7	Өөрийн сургуулийн МСҮТ-ийг “А” үнэлгээтэй төгссөн оюутныг нэгдүгээр улиралд нийт төлбөрөөс үзүүлэх хөнгөлөлтийн хувь (хоёрдугаар улирлаас дээрх үзүүлэлтийг харгалзана)	100%

8	Бусад МСҮТ болон ЕБС-ийг “А” үнэлгээтэй төгссөн оюутныг нэгдүгээр улиралд нийт төлбөрөөс үзүүлэх хөнгөлөлтийн хувь	<b>20%</b>
---	--	------------